



Хүүхдийнхээ

Бага Боловсролын Стандартад Суурилсан Сурлагын Явцын Тайлантай Танилцах Тухай

АУС бага боловсролын стандартад суурилсан сурлагын явцын тайланд зарим шинэчлэл хийлээ. Эдгээр өөрчлөлтийг оруулснаар танай сурагчийн суралцах хугацааны сурлагын явцын мэдээлэл илүү нарийвчилсан бөгөөд тодорхой болж байгаа юм.

Сурлагын Түвшин

Хүүхдийн сурлагын явцыг мэдээлэхдээ 4 шатлал бүхий сурлагын түвшнийг ашиглана.

1 – Стандартыг Ойлгож Буй:

Сурагч стандартын анхан шатны ойлголттой болж буйг бусдын тусламжтайгаар илэрхийлнэ.

2 – Стандартад дөхөж Буй:

Сурагч стандартын хэсэгчилсэн, тууштай бус ойлголттой болж буйг бие дааж илэрхийлнэ.

3 – Стандарт Хангаж Буй:

Сурагч стандартыг бүрэн, тууштай ойлгож буйг бие дааж илэрхийлнэ.

4 – Стандартаас Давж Буй:

Сурагч стандартыг хангахаас гадна стандартын гүнзгийрсэн мэдлэг, хэрэглээтэйг илэрхийлнэ.

Чухал Өөрчлөлтүүд

Илүү Нарийвчилсан Мэдээлэл: Явцын тайланд тухайн анги болон хичээл тус бүрд хамаарах тухайн жилд эзэмшсэн чухал шаардлагатай мэдлэгүүдийг багтаасан байна.

Бүтэн Жилийн Эрдмийн Аян: Одоо бид сурлагын явцын тайланг хичээлийн жилийн эцсийн стандарттай жишиж мэдээлдэг болсноор хүүхдийн хичээлийн явц хэрхэн өрнөж буйг харуулах боломжтой боллоо. Ингэснээр улирал тутам хүүхдийнхээ мэдлэгийг **жилийн эцэст эзэмшвэл зохих стандарттай** харьцуулан харах боломжтой юм.

Тайлангийн Бүтцийг Хялбаршуулаа: 4-5 хуудас байсан явцын тайлангийн хуудсыг 2 хуудас болгож хураангуйлав.

Санал Сэтгэгдлийг Сайжруулаа: Одоо хичээл бүрд хамаарах санал сэтгэгдэл бичих хэсэгтэй болов. Ерөнхий санал сэтгэгдлийг "Давуу тал ба Зорилтууд" хэсгээр орлуулснаар сурагчийн талаар тодорхой санал сэтгэгдэл, тайлбар өгөх боломжтой боллоо.

Эдгээр нь танай хүүхдэд хэрхэн хамаарах вэ

Тодорхой Суралцах Замнал: Хичээлийн жилийн эцсийн стандарттай жишиж үнэлснээр та хичээлийн эцсийн зорилгоо харж, улмаар таны хүүхэд хэрхэн ахиц гаргаж буйг хянах боломжтой болно.

Тасралтгүй Суралцах Явц: Сурагчид хичээлийн жилийн эхэнд 1 болон 2 гэсэн үнэлгээ илүү авах магадлалтай. Энэ нь тодорхой стандартуудыг улирал дараалан үргэлжлүүлэн заах хичээлийн явцыг харуулах бөгөөд хичээлийн жилийн эцэст стандартыг тууштай ойлгох (**стандартыг хангах** г.м) түвшинд хүрэх эцсийн зорилгыг илтгэнэ.

Өсөлтийн Сэтгэлгээ: Хүүхдийнхээ хичээл зүтгэл, тэвчээр, алхам алхмаар гаргасан ахиц дэвшлийг урамшуулж, өсөлтийн сэтгэлгээг нь төлөвшүүлээрэй. Хүүхдийнхээ юу сурч байгааг ярилцаж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нээлттэй асуултуудыг асууж ярилцах нь зүйтэй.

Мэдээлэлтэй Байх

Улирал тутамд хүүхдийн тань багш ангид өрнөж буй хичээлийн үйл явцын тухай шинэчилсэн мэдээллийг тогтмол өгөх болно. Даалгаврууд нь тухайн ерөнхий стандартын тодорхой хэсгүүдэд таны хүүхдийн ахицыг харуулах юм.

Стандартад суурилсан сургалт, үнэлгээ, тайлангийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах АУС-ийн вэбсайтаас авна уу: www.apsva.us/curriculum/standards-based-grading/ (<http://www.apsva.us/curriculum/standards-based-grading/>)

Хэрэв танд нэмэлт асуулт гарвал хүүхдийнхээ багштай холбоо барих буюу эсвэл Сургалтын Хөтөлбөр, Заах Арга Зүйн Газрын Гүйцэтгэх Захирал Сара Путнам (Sara Putnam)-тай sarah.putnam@apsva.us имэйлээр холбогдоно уу.